



BULIGAR
BOVINE SKIN TANNERY
EST. 1934

2024



**БУЛИГААР ХУВЬЦААТ КОМПАНИ
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

**БУЛИГААР ХУВЬЦААТ КОМПАНИ
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд 2-оос доошгүй удаа тооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1.	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		100%
2.	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100%
3.	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		66.6%
4.	Аудит, хяналтын тогтолцоо	6	5		83.3%
5.	Эрсдэлийн удирдлага	8	8		100%
6.	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100%
7.	Оролцогч талуудын эрх ашиг	8	5		62.5%
8.	Компанийн соёл	6	6		100%

9.	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	8		80%
----	--------------------------	----	---	--	-----

3. Үнэлгээний аргачлал

- 3.1 Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.
- 3.2 Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ.
- 3.2.1. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 3.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

4. Үнэлгээний асуулга

“БУЛИГААР” ХК

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн.	2022.05.04-ний 08/22 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталж мөрдөж байгаа. Энэхүү журмын 6, 7, 8, 9 дүгээр бүлэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан байгаа. Мөн 2023, 2024 онуудын ХЭ-ийн ээлжит хуралд ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг тайлгасан байгаа. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хавсралтаар илгээв.	2	100%
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 3, 4, 5 дугаар бүлэгт нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан бөгөөд 2022.10.14-ний өдрийн 21/22 тоот тогтоолоор Залгамж халааны бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү бодлогод залгамж халааг бэлтгэх, гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан.	2	100%
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2021, 2022, 2023 оны жилийн үйл ажиллагааны тайланд Булигаар ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдлын мэдээллийг тусгасан. https://www.mse.mn/issuers/activityreport/38_20240416064323report.pdf /хуудас 7-11/ Мөн тайлант хугацаанд ТУЗ-ийн хороодын үйл ажиллагаа, хурлын давтамж зэрэг мэдээллүүд багтсан байна. https://www.mse.mn/issuers/activityreport/38_20240719103728report.pdf /хуудас 5/ ТУЗ болон түүний дэргэдэх хороодын тайланг гаргасан.	2	100%

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			ТУЗ-ийн дарга, гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийг тус компанийн ТУЗ-ийн дэргэдэх “Нэр дэвшүүлэх хороо” хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгдөг бөгөөд 2024 оны ажлын гүйцэтгэлийн дүгнэлт болон үнэлгээний хуудсыг хавсралтаар илгээв.		
4	1.4. Компани нь ТУЗ-ийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршилагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11 дүгээр бүлэгт нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний талаар тусгаад зогсохгүй ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэмд бүтэц, зохион байгуулалтын талаар тусгасан. Мөн хууль журмын дагуу ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь Аудитын хороог даргалдаг ба хороо тус бүр хариуцсан үүрэг хариуцлагынхаа хүрээнд шийдвэр гаргаж, ТУЗ-д зөвлөмж өгч, Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянаж ажилладаг. Мөн ТУЗ-ийн хурлаар үйл ажиллагааны тайлангаа тогтмол тайлагнаж ажилладаг. Тус хороодод хамгийн чухал тавигддаг шаардлага болох Хараат бус гишүүдийн оролцоог бүрэн хангасан ба ТУЗ-ийн нийт Хараат бус 3 гишүүн тус тусдаа хорооны даргаар ажилладаг ба ТУЗ-ийн нийт буюу 3 эмэгтэй гишүүд хороодын гишүүнээр ажиллаж байна. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүдийн 33% буюу 9 гишүүний 3-н эмэгтэй гишүүн байгаа.</p> <p>ТУЗ-ийн 2024.04.19-ний өдрийн 09/24 тоот тогтоолоор Хороодын гишүүд томилсон тогтоолыг хавсралтаар илгээв.</p> <p>ТУЗ-ийн 2024.06.24-ний өдрийн 14/24 тоот тогтоолоор “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.8-д “ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалж, аль нэг хүйсийн эзлэх хувь гучаас доошгүй байхыг эрмэлзэнэ” <u>ХЭМЭЭН</u> нэмэлт заалтыг оруулан баталсан бөгөөд энэхүү тогтоолыг хавсралтаар илгээв.</p>	2	100%
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулсан 2024 оны жилийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсралтаар илгээв.</p> <p>Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь 1 жилийн хугацаатайгаар томилогддог тул сургалтын төлөвлөгөөг 2025.05-2026.04 хүртэлх хугацаанд төлөвлөсөн болно.</p>	2	100%

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 8 дугаар бүлэгт нь ТУЗ-ийн нарийн бичгийн үүрэг, хариуцлагыг тусгасан байгаа. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2024 оны ажлын тайланг хавсралтаар илгээв.	2	100%
ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь нийт 9 гишүүнтэй бөгөөд нийт гишүүдийн 3/1 буюу 3 хараат бус гишүүнтэй. ТУЗ-ийн дэргэдэх хороодын дарга нь хараат бус гишүүд байдаг. 1. ТУЗ-ийн дэргэдэх хороо тус бүрийн 2024 оны ажлын тайланг хавсралтаар илгээв. 2. ТУЗ-ийн 2024.06.24-ний 14/24 тоот тогтоолоор “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1-д “ТУЗ-ийн гишүүдийн тоо, бүрэлдэхүүнийг Компанийн дүрмээр зохицуулна. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.” хэмээн нэмэлт заалтыг оруулан баталсан бөгөөд энэхүү тогтоолыг илгээв. 3. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, комплайнсын ажилтны анкетыг хавсралтаар илгээв.	2	100%
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм 2022 оны 10-р сард баталсан. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн Ч.Нямдорж ажилладаг бөгөөд Аудитын хорооны гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байдаг. Аудитын хорооны үйл ажиллагааны журмын 3.20-д хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно гэж заасан. 2024.04.19-ний өдрийн 09/24 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар хараат бус гишүүнийг томилсон бөгөөд энэхүү тогтоолыг илгээв.	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
9	<p>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журамтай байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг 2022 оны 10-р сард баталсан. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн Ж.Эрдэнэбат ажилладаг. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцдог. 2024.04.19-ний өдрийн 09/24 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүнийг томилсон бөгөөд энэхүү тогтоолыг илгээв.</p>	2	100%
10	<p>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам болон Залгамж халааны бодлогын бичиг баримтыг 2022 оны 10-р сард баталсан. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн Ч.Болд ажилладаг. 2024.04.19-ний 09/24 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүнийг томилсон бөгөөд түүнийг томилсон шийдвэрийг илгээв.</p>	2	100%
11	<p>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11 дүгээр бүлэгт нь ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлсон бөгөөд ТУЗ нь дэргэдээ нийт 3 хороодтой. Үүнд: Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо. Хороод нь бүгд үйл ажиллагааны журамтай бөгөөд хороодын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй. Хавсралтаар анкетыг илгээв. https://issuers.mse.mn/issuers/shiidbertuz/38_2024-04-19%2016:00tuz_togtool1927600262.pdf</p>	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	2022.12.16-ны өдрийн 24/22 тоот тогтоолоор Мэдээлэл хүргэх журмыг баталсан. Энэхүү журмын 4-р бүлэгт нийтэд хүргэх мэдээллийн жагсаалтыг баталсан. Тайлант хугацаанд хамаарах зохицуулагчийн холбогдох журмын дагуу санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг нийтэд ил тод болгох мэдээллийг хууль журмын дагуу цахим хуудас, жилийн тайлан, зохицуулагчид тус тус тогтмол тайлагнаж, хянадаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.		Компани нь шинээр цахим хуудастай болсон даруйд кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг дамжуулан мэдээлэх болно. Одоогоор санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан компанийн цахим хуудас шинээр хийлгүүлэх нөхцөл бүрдэхгүй байгаа.	0	0%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жил бүрийн компанийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт хангалттай цэвэр гарсан ба ямар нэгэн санхүүгийн хүндрэлтэй байдалд орж болзошгүй зүйл байхгүй болно. Санхүүгийн бус тайлагналын хүрээнд 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/ болон 2024 оны улирал тутмын үйл ажиллагааны тайлан /маягт 2/-д эдийн засгийн орчин, компанийн стратегийн зорилтуудад хүрэхэд ямар үр дүн гаргасан болон нийгмийн хариуцлага, компанийн засаглал, зах зээлийн эрсдэл бий эсэх талаарх тайлан, мэдээ, мэдээллийг оруулсан. Мөн ХЭ-ийн ээлжит хуралд санхүүгийн болон санхүүгийн бус тайлагналын хүрээнд компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэх зэргийг тусад нь бэлтгэн мэдээлэлдэг. 2024 оны улирал тутмын үйл ажиллагааны тайлан болон ХЭ-ийн ээлжит хуралд танилцсан материалыг хүргүүлэв.	2	100%
ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой	Бүрэн хэрэгжүүлсэн	Хөндлөнгийн аудитортой харьцах талаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 11.4.3 заалтад тусгасан. Үүнд:	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
	<p><i>харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.</i></p>		<p>a. Хөндлөнгийн аудиторыг сонгох асуудлаар санал гаргах, үүнд аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдал, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт болон аудитын ажлын хөлс, аудитын дүгнэлтийн агуулга, чиглэл зэрэг асуудал орно;</p> <p>b. Хөндлөнгийн аудиторын ажилд жил бүр үнэлэлт дүгнэлт өгөх, тухайн аудитын байгууллагатай гэрээгээ сунгах, эсхүл цуцлах асуудлаар санал бэлтгэх ба хөндлөнгийн аудитын үйл ажиллагааг дүгнэсэн, сонгон шалгаруулсан үндэслэлээ ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;</p> <p>c. Хөндлөнгийн аудитортой хамтран тухайн жилийн аудитын ажлын чиглэл, төлөвлөгөө, аудитын дагаж мөрдөх дотоод дүрмийг батлах бөгөөд ингэхдээ Компанийн тухайн үеийн нөхцөл байдал, хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг харгалзан үзэх ба мөн хөндлөнгийн аудитортой байгуулах гэрээний төслийг боловсруулах;</p> <p>d. Аудиторын хэвийн ажиллагаанд саад бэрхшээл учруулсан ямар нэг асуудал гарсан (үүнд аудитын ажиллагааг ямар нэг байдлаар хязгаарласан, шаардлагатай мэдээллийг хугацаанд гаргаж өгөөгүй зэрэг асуудал багтана) бол түүнийг шийдвэрлэх;</p> <p>e. Хөндлөнгийн аудиторын шалгалтын явцад илэрсэн зөрчил, түүний гаргасан зөвлөмж болон гүйцэтгэх удирдлагын зүгээс тухайн зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаар хэлэлцэх;</p> <p>f. Хөндлөнгийн аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах эсэхийг шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах боломжийг хангах;</p> <p>g. Аудитын хороо, эсвэл хөндлөнгийн аудитор тодорхой асуудлыг хаалттай хэлэлцэх шаардлагатай гэж үзвэл ганцаарчилсан уулзалт зохион байгуулах, аливаа асуудлаар шаардлагатай үед аудиторыг Аудитын хорооны даргатай чөлөөтэй уулзах боломжийг хангах;</p> <p>h. Хөндлөнгийн аудитороор аудитын бус үйлчилгээ, даалгавар гүйцэтгүүлэх нь түүний хараат бус байдалд нөлөөлөх эсэх талаар холбогдох АОУС болон аудитын байгууллагын дотоод стандартад хэрхэн тусгасныг судлах, энэ</p>		

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			асуудлаар Компаниас баримтлах бодлогыг батлах ба шаардлагатай тохиолдолд аудитор нь аудитын бус үйлчилгээг үзүүлэхдээ урьдчилан Аудитын хорооноос зөвшөөрөл авдаг байх тогтолцоог бий болгох; i. Аудитын байгууллагыг заавал солих хугацааны талаарх хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх талаар Компанийн бодлогыг боловсруулах, энэхүү бодлого нь хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан байх нөхцөлийг хангах.		
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Бүрэн хэрэгжү үлсэн.	2023 болон 2024 оны ХЭ-ийн ээлжит хуралд хөндлөнгийн аудиторын оролцож, аудитын үр дүнг ХЭ-д танилцуулсан. /2023 болон 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлын тэмдэглэлд бичигдсэн байгаа бөгөөд хурлын үеийн фото зургийг дараах линкээр орж хуудас 4-өөс үзэх боломжтой./ https://www.mse.mn/issuers/activityreport/38_20240719103728report.pdf	2	100%
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.</i>	хэрэгжү үлсэн.	Компани нь дотоод аудиттай боловч дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг тайланг компанийн үйл ажиллагааны тайланд мэдээлээгүй бөгөөд 2024 оны үйл ажиллагааны тайланд тусгах болно. Компанийн дотоод аудитын 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралтаар илгээв.	1	50%
ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны</i>	Бүрэн хэрэгжү үлсэн	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо хариуцан ажилладаг бөгөөд Аудитын хорооны дарга, гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байдаг.	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
	<i>үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>		2024.04.19-ний 09/24 тоот ТУЗ-ийн тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог байгуулж хорооны даргаар хараат бус гишүүнийг томилсон. Тус тогтоол, шийдвэрийг хавсралтаар илгээв.		
19	<i>5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Бүрэн хэрэгжү үлсэн	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг аудитын хороо хариуцдаг. Аудитын хорооны дарга, гишүүдийн олонх нь хараат бус гишүүн мөн. Аудитын хорооны бүтэц, хурлын давтамжийн талаар тайлгадаг болно. Аудитын хорооны тайланг хавсралтаар илгээв.	2	100%
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Бүрэн хэрэгжү үлсэн	Тус компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг асуудлын хүрээнд БОАЖЯ-аас Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхтэй “Хан гэрэл экологи” ХХК-иар “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г гүйцэтгүүлэн 2024 онд БОАЖЯ-ны Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлуулсан. Түүнчлэн БОННУ-г үндэслэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох төрийн байгууллагуудад жил тутам батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж байгаа. 2024 оны төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хавсаргав. Түүнчлэн 2024 оны 6 сард ХУД-ийн 20-р хорооны иргэд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан	2	100%

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			үнэлгээний тайланг танилцуулсан байгаа. Хавсралтаар хурлын тэмдэглэлийг илгээв.		
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2022.10.14-ний өдрийн 21/22 тоот тогтоолоор Комплайнсын хяналтын бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү бодлогод комплайнсын ажилтны бие даасан, хараат бус байдлыг хангахын тулд ТУЗ-д ажлаа тайлагнахаар тусгасан байгаа. ТУЗ-ийн 2024.06.24-ний өдрийн 16/24 тоот тогтоолоор комплайнсын ажилтныг томилсон бөгөөд энэхүү тогтоол болон комплайнсын ажилтны ажлын тайланг тус тус хавсралтаар илгээв.	2	100%
ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2024.04.19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ил тод хэлэлцүүлж ХЭ-ийн ээлжит хурлын 03/24 тоот тогтоолын хавсралтаар багтагдсан. Энэхүү тогтоолыг хавсралтаар илгээв.	2	100%
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2022.10.14-ний өдрийн 21/22 тоот ТУЗ-ийн тогтоолоор Компанийн цалин, урамшууллын бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү бодлогод Цалин, урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална: <ul style="list-style-type: none"> • Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох; • Цалин, урамшууллын хуваарилалтад аливаа ялгаварлал, гадуурхал, тэгш бус байдлыг гаргахгүй байх; • Цалин, урамшууллыг ур чадвар болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох; • Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах; • Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалын дагуу ажиллагсдын цалин, 	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			<p>урамшууллыг шударга хуваарилах, хөдөлмөрчдийн эвлэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээр болон хамтын гэрээ байгуулах эрхийг хүлээн зөвшөөрөх.</p> <p>Энэхүү бодлогын 2.2.2-д заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнд хуралд оролцсон цалинг олгодог. Компанийн нийт ажилтны цалин урамшууллын хувьд тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд энэхүү бодлогод нийцүүлэн Гүйцэтгэх удирдлагаас үндсэн цалингаас гадна, урамшууллыг шинэчлэн тогтоодог.</p>		
24	<p><i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i></p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компанийн гүйцэтгэх удирдлагын цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг ТУЗ-аас гүйцэтгэх удирдлагатай байгуулах “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ийн 6-р заалтад тусгасан байгаа.</p> <p>Гэрээний маягтыг хавсралтаар илгээв.</p> <p>Жич: Тус компанид 2024.04.21-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан тус компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Б.Анхболд нь өнгөрсөн хугацаанд компаниас цалин, шагнал, урамшуулал огт авч байгаагүй болно. Энэ талаар жилийн үйл ажиллагааны тайлангийн 4 дэх заалтад тусгасан.</p>	2	100%
<p>ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ</p>					
25	<p><i>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i></p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>2023.06.09-ний өдрийн 09/23 тоот ТУЗ-ийн тогтоолоор Оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлогын баримт бичгийг батлагдсан бөгөөд бодлогын баримт бичгийг илгээв.</p>	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	хэрэгжүүлсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хэрхэн ажилласан талаар 5-р заалтад тусгагдсан бөгөөд компанийн цахим хуудсыг 2025 оны 1-р улиралд багтаан ашиглалтад оруулахаар зорьж байна.	1	50%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.		Компанийн цахим хуудсыг ашиглалтад оруулахаар зорьж байгаа бөгөөд кодекст заасан мэдээллийг 2025 оны 1-р улиралд багтаан цахим хуудаст байршуулахаар төлөвлөж байна.	0	0%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	<p>Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг компанийн дараах баримт бичгүүдээр батлагдсан зохицуулалтын хүрээнд асуудлуудыг хүлээн авч, шийдвэрлэж ажилладаг. шинэ ажилтанд болон нийт ажилтнуудад зориулсан сургалтыг тухай бүрд нь зохион байгуулагддаг.</p> <ul style="list-style-type: none"> – 2023.10.02-ний өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар Ж23-ҮХН-25-01 тоот Саналын хайрцаг ажиллуулах тухай журмыг баталсан ба энэхүү журмын дагуу ажилтны санал хүсэлт, гомдлыг саналын хайрцагаар хүлээн авахаар зохицуулагдсан байгаа. – 2022.10.14-ний өдрийн ТУЗ-ийн 21/22 тоот тогтоолоор Комплайнсын хяналтын бодлогын баримт бичгийг 5.5-р заалт баталсан. – 2022.12.16-ны өдрийн ТУЗ-ийн 23/22 тоот тогтоолоор Ёс зүйн зөрчил, хууль бус үйлдлийг мэдээлэх /шүгэл үлээх журмыг тус тус баталсан. <p>Компанийн дотоод журам, сургалт хөгжлийн журмуудыг баталсан ба нийт ажилтнуудын нийгэм ахуйн асуудлыг энэхүү журмын хүрээнд шийдвэрлэдэг. Түүнчлэн ажилтнуудын ур чадвар, мэдлэг туршлагыг тасралтгүй сайжруулах, хөгжүүлэх зорилгоор сургалт хөгжлийн хэрэгцээ тодорхойлох, сургалт хөгжлийн хөтөлбөр зохион байгуулах, сургалтыг үнэлэх болон бусад харилцааг зохицуулдаг.</p>	2	100%

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			Компанийн албан тушаалын ур чадварын матрицтай уялдуулсан сургалт хөгжлийн моделийн дагуу ажилтнууд бэлтгэх, хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг.		
НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Булигаар ХК-ийн алсын хараа: Дээд зэргийн чанартай арьсыг хэрэглэгчдийн таашаалд нийцсэн үнээр нийлүүлдэг арьс ширийн зах зээлийн тэргүүлэгч компани байна. 2022.12.16-ны өдрийн ТУЗ-ийн 23/22 тоот тогтоолоор Ёс зүйн дүрмийг баталсан бөгөөд ТУЗ нь хэрэгжилтэд хяналт тавин ажилладаг.	2	100%
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	2022.12.16-ны өдрийн ТУЗ-ийн 23/22 тоот тогтоолоор Ёс зүйн зөрчил, хууль бус үйлдлийг мэдээлэх журмаар шүгэл үлээгчийн тогтолцоо бий болгосон бөгөөд – Цахим хэлбэрээр илгээвэл, info@buligaar.com гэсэн цахим хаягаар; – Бичгээр хэлбэрээр ирүүлбэл, ТУЗ-ийн нарийн бичигт хүргүүлэх; – Шуудангаар илгээвэл, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо АШҮХ, Булигаар ХК-ийн байр, 2-р давхарт гэсэн хаягаар; – Утсаар мэдэгдвэл, /комплайнсын ажилтны дугаар/ – Биечлэн уулзах зэрэг сувгуудаар хүлээн авдаг. Шүгэл үлээх сувгаар ирсэн мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг байгууллагын нууц хадгалах журмын дагуу нууцад тооцож чанд хадгалах бөгөөд Комплайнсын ажилтан хандах эрхтэй байдаг.	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Бүрэн хэрэгжү үлсэн	2022.12.16-ны өдрийн ТУЗ-ийн 23/22 тоот тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийн 3.3 дахь заалтад авилгын талаар зохицуулалт, 4.2 дахь заалтад “Компани нь улс төрийн нам, эсвэл, хөдөлгөөн, улс төрийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэнд шууд болон шууд бусаар аливаа хандив өгөх, дэмжлэг үзүүлэх тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан хэлбэрээр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаар зохион байгуулна.” гэсэн зохицуулалтыг тусгасан.	2	100%
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	<i>9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.</i>	хэрэгжү үлсэн	Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллүүд, жилийн үйл ажиллагааны тайлан, засаглалын зохион байгуулалт, санхүүгийн байдлын талаарх тайланг жилээр болон хагас жилээр, улирлаар тайлагнан ажилладаг ба бүтээгдэхүүн болон цаг үеийн мэдээллийг Монголын Хөрөнгийн биржийн сайтаар дамжуулан шуурхай тухай бүр хүргэхийг зорьдог. Түүнчлэн энэхүү мэдээллүүдийг Компанийн цахим хуудсыг ашиглалтад оруулахаар зорьж байгаа бөгөөд Кодекст заасан мэдээллийг 2025 оны 1-р улиралд багтаан цахим хуудаст байршуулахаар төлөвлөж байна.	1	50%
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	хэрэгжү үлсэн	Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигч нартай харилцах тогтолцоог хууль журмын дагуу бий болгосон ба жил бүрийн сүүлээр дараагийн жилийн ажлын төлөвлөгөө, ээлжит хурлын товуудыг гаргаж оролцогч талуудад мэдээллийг хүргүүлж ажилладаг. Үүний дагуу ямар мэдээлэл хэзээ гаргах, хүргэгдэх зэрэг харилцаа төлөвлөгөө хөтөлбөр байдлаар гарч хэрэгжүүлдэг. 2023.06.09-ний өдрийн 09/23 тоот ТУЗ-ийн тогтоолоор Оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлогын баримт бичгийг баталсан. Энэхүү бодлогын бичиг баримтад компанийн хувьцаа эзэмшигч, ажилтан, хэрэглэгч, харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчид, зохицуулагчтай хэрхэн харилцах, хамтын ажиллагааг тодорхойлсон.	1	50%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
			<p>Үүнтэй холбоотой хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим хаягийг нээж ажиллаж байна.</p> <p>ТУЗ-ийн 2023.06.09-ний өдрийн 09/23 тоот тогтоолоор Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах хөтөлбөрийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийг хавсралтаар илгээв.</p> <p>Түүнчлэн 2022.12.16-ны өдрийн ТУЗ-ийн 24/22 тоот тогтоолоор батлагдсан Мэдээлэл хүргэх журмыг баталсан бөгөөд Компанийн цахим хуудсыг хөгжүүлэн цаашид дамжуулан мэдээлэхийг зорих болно.</p>		
34	<p>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, боломжоор хангагдсан бөгөөд хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй 54 брокер, дилерийн компаниудын майл хаяг руу info@buligaar.com гэсэн өөрийн компанийн майл хаягнаас цахим хэлбэрээр 2024.04.19-ний өдрийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичиг бүхий тараах материалыг 2 удаагийн давтамжтайгаар хүргүүлсэн. 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлын тэмдэглэлээс хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж нөхцөлийг бүрдүүлсэн эсэхийг харах боломжтой бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуулийн дагуу зохион байгуулдаг. Хавсралтаар баримтыг илгээв.</p>	2	100%
35	<p>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу эдгээр асуудлаар санал өгөх эрхээ хэрэгжүүлэх нөхцөлөөр бүрэн хангагддаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуулийн дагуу зохион байгуулдаг. 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлыг хянасан тухай СЗХ-ноос ирүүлсэн албан бичгийг хавсралтаар илгээв.</p>	2	100%
36	<p>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх</p>	<p>Бүрэн хэрэгжүүлсэн</p>	<p>1. 2024.06.24-ний 15/24 тоот ТУЗ-ийн тогтоолоор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баталсан бөгөөд хавсралтаар илгээв.</p> <p>2. 2024 онд Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бөгөөд СЗХ-оос өгсөн чиглэлийн дагуу ХЭ-ийн ээлжит бус хурлаар уг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгогдсон болно. 2024 оны ХЭ-ийн ээлжит бус хурлын</p>	2	100%

№	Зүйл	Хэрэг-жилт	Тайлбар	Үнэлгээ	Хувь
	<i>журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>		тэмдэглэлээс хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж нөхцөлийг бүрдүүлсэн эсэхийг харах боломжтой бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуулийн дагуу зохион байгуулдаг.		

Хавсралтаар:

1. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан /1.1-р зүйлд хамаарах/
2. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны дүгнэлт, үнэлгээний хуудас /1.3-р зүйлд хамаарах/
3. ТУЗ-ийн 2024.04.19-ний өдрийн “ТУЗ-ийн дэргэдэх хороодыг томилсон тухай” 09/24 тоот тогтоол /1.4, 2.2, 2.3, 2.4, 5.1-р зүйлд хамаарах/
4. ТУЗ-ийн 2024.06.24-ний өдрийн 14/24 тоот тогтоол /1.4, 2.1-р зүйлд тус тус хамаарах/
5. ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулсан 2024 оны жилийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт /1.5-р зүйлд хамаарах/
6. ТУЗ-ийн нарийн бичгийн 2024 оны ажлын тайлан /1.6-р зүйлд хамаарах/
7. ТУЗ-ийн дэргэдэх хороо тус бүрийн 2024 оны ажлын тайлан /2.1, 5.2-р зүйлд хамаарах/
8. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн, комплайнсын ажилтны анкет /2.1, 2.5-р зүйлд хамаарах/
9. 2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан /3.3-р зүйлд хамаарах/
10. 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлын танилцуулга материал /3.3-р зүйлд хамаарах/
11. 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлын тэмдэглэлийн 6-7 хуудас /4.2-р зүйлд хамаарах/
12. Компанийн дотоод аудитын 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан /4.3-р зүйлд хамаарах/
13. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан /5.3-р зүйлд хамаарах/
14. ХУД-ийн 20-р хорооны иргэдийн хурлын тэмдэглэл /5.3-р зүйлд хамаарах/
15. 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан /5.3-р зүйлд хамаарах/
16. ТУЗ-ийн 2024.06.24-ний өдрийн 16/24 тоот “комплайнсын ажилтныг томилох тухай” тогтоол /5.4-р зүйлд хамаарах/
17. 2024.04.19-ний өдрийн ХЭ-ийн ээлжит хурлын 03/24 тоот “ТУЗ-ийн зардлын төсөв батлах тухай” тогтоол /6.1-р зүйлд хамаарах/
18. Гүйцэтгэх удирдлагын цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгасан Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээ /6.3-р зүйлд хамаарах/
19. Оролцогч талуудтай харилцах хамтран ажиллах бодлогын баримт бичиг /7.1-р зүйлд хамаарах/
20. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого, хөтөлбөр /9.2-р зүйлд хамаарах/
21. ХЭ-ийн оролцоог хангаж брокер, дилерийн компаниудад цахимаар хүргүүлсэн баримт /9.3-р зүйлд хамаарах/
22. 2024 оны ХЭ-ийн ээлжит хурлыг хянасан тухай СЗХ-ноос ирүүлсэн албан бичгийн хуулбар /9.4-р зүйлд хамаарах/
23. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам /9.1, 9.5-р зүйлд тус тус хамаарах/